

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-7

---

- 1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**  
*Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
06 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Болормаа, Г.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Д.Үүрийнтуяа, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: П.Мөнхтулга, Да.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Ж.Ганбаатар;

Тасалсан: Т.Аубакир, Д.Батбаяр, Д.Пүрэвдаваа, Г.Тэмүүлэн.

**Нэг. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга М.Санжаадорж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Оюунболд, мөн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга Э.Балт, Барилга, байгууламжийн зураг төсөл, магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд, Барилга, байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Д.Батням, Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүний ажлын албаны зөвлөх Б.Нэргүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн  
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:**

**Н.Наранбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн нэрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж, төслийн 1 дэх заалтын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” гэснийг “Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн

өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид “төсвийн хөрөнгө оруулалт” гэх/-аар” гэж тус тус өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “хэрэгжүүлж байгаа” гэсний өмнө “болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр” гэж нэмж, төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1-д заасан тайланд тусгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шинжээч томилох тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам,

зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин дээрх асуудлыг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул, хуралдаан хаалттай горимд шилжив.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Нээлттэй хуралдаан 10 минут үргэлжилж, 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Номин, Дашцэрэнгийн Энхтүвшин, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жамбын Батсуурь, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвжавын Сайнзориг, Ренчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа нарын гишүүд ирж ирц 56.7 хувиар бүрдсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56,7 хувьтай бүрдсэн тул 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг

2.Байнгын хорооны тогтоолын төсөл “Шинжээч томилох тухай”

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Байхгүй, алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

**“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батболдын Мөнхтөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Далхаагийн Оюунболд “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Эрдэнэбаярын Балт “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга, Ганхуягийн Мөнхболд “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга, байгууламжийн зураг төсөл, магадлал, зохион байгуулах хэлтсийн дарга, Дашзэвэгийн Батням Барилга, байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга, Банзаарайгийн Нэргүй Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Дармаагийн Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр, уг асуудлыг гүйцээн боловсруулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн асуудлаар санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Зарчмын зөрүүтэй 3 саналын томъёолол байгаа. Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн  
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

1.Тогтоолын төслийн нэрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж, төслийн 1 дэх заалтын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” гэснийг “Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид “төсвийн хөрөнгө оруулалт” гэх/-аар” гэж тус тус өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар. Санал хураалтад бэлэн үү гишүүд. 9 гишүүн бэлэн болсон байна. Алтанхуяг гишүүнийх. Санал хураалт явуулъя.санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “хэрэгжүүлж байгаа” гэсний өмнө “болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр” гэж нэмж, төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1-д заасан тайланд тусгах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

10.16 цаг.

2 дахь асуудалдаа орё.

Энхтүвшин гишүүн горимын санал гаргана.

**Д.Энхтүвшин:** 2 дахь асуудал дээр ерөнхий хяналтын сонсгол явуулахтай холбогдуулж шинжээч томилох асуудал байгаа. Тэгээд энэ шинжээч нарын асуудал бас судалгааны ажилд шинжээчдийн ажлын үр дүнд нөлөөлж магадгүй учраас хаалттай горимоор явуулъя гэсэн саналтай байна.

**Н.Наранбаатар:** 2 дахь асуудал дээр Энхтүвшин гишүүн горимын санал гаргасан. Тэгээд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад бэлтгээрэй гишүүд. 10 гишүүн бэлэн болсон байна. Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар хаалттай хуралдаанд шилжүүлье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар дэмжигдлээ. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*